



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2010 оны 6 сарын 16 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-ыг хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ыг батлах тухай 242 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам”-ын маягт-1А, маягт-1Б-д нэмэлт өөрчлөлт оруулж хавсралт 2-оор баталсугай.

5.Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 14.2.4, 25.2, 25.3 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон компани (цаашид “даатгагч” гэх)-ийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад оновчтой байршуулахад оршино.

1.2. Даатгагчийн хөрөнгө оруулалтын зорилго нь даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, даатгагчийн мөнгөн хөрөнгийг хангалттай хүрэлцэхүйц, баталгаатай байлгахад оршино.

1.3. Даатгагч хөрөнгө оруулалт хийхдээ учирч болох дараах үндсэн эрсдэлүүдийг тооцоолох шаардлагатай:

1.3.1. Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн үнийн өөрчлөлт болон хувирамтгай байдлаас үүдэн даатгагчийн санхүүгийн нөхцөл байдалд хохирол учирч болзошгүй юм. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, эзэмшигчийн өмч болон үл хөдлөх хөрөнгийн эрсдэл, валютын ханшийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

1.3.2. Зээлийн эрсдэл. Үнэт цаас гаргагч, зээлдэгч, харилцагч түнш болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын зээлийн чанар буурах болон зээл хугацаандаа төлөгдөөгүйн улмаас даатгагч санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй. Энэ төрлийн эрсдэлд зээл төлөгдөхгүй байх, зээлийн чанар буурах, шууд бус зээл, эсвэл зээлийн тархалтын эрсдэл, төвлөрлийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

1.3.3. Хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрвөх чадварын үнэлгээний эрсдэл, салбаруудад оруулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл, хөрөнгийн сангийн эрсдэл зэрэг эрсдэлүүд орно.

1.4. Даатгагчид энэ журмын 1.3-т заасан эрсдэлүүдийг удирдахад дараах шаардлага тавигдана:

1.4.1. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг удирдах бодлого, стратегитай байх;

1.4.2. Энэ журмын 1.4.1-т заасан бодлого, стратегийн дагуу хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай арга замыг сонгож хэрэгжүүлэх;

1.4.3.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хянах, үнэлэх, тайлагнахад тохиромжтой системтэй байх.

1.5.Хорооноос энэ журмын 1.4-т заасан даатгагчийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд даатгагчийн хөрөнгө оруулалтын эрсдэлийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээний аргачлал, хяналтын болон тайлагналтын горим зэрэгт хяналт тавина.

1.6.Энэ журмын дор дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.6.1.“Даатгагчийн нийт хөрөнгө” гэж балансын актив дахь нийт хөрөнгийн дүнг хэлнэ.

1.6.2.“Банк” гэж Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй банкиг хэлнэ.

1.6.3.“Үл хөдлөх хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ. Аливаа зээлийн барьцаанд тавьсан, эсхүл төлбөрийн баталгаа болгосон хөрөнгийг үл хөдлөх хөрөнгөд оруулж тооцохгүй.

1.6.4.“Буруутай этгээдээр төлүүлсэн нөхөн төлбөр болон даатгагчийн авсан даатгуулагчийн сүйрсэн хөрөнгө” гэж даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид бүрэн олгосны дараагаар даатгагч хохирлын буруутай этгээдээс нөхөн төлүүлж авсан төлбөр болон орлогод тооцож авсан даатгуулагчийн эвдэрч гэмтсэн хөрөнгийг хэлнэ.

1.6.5.“Компанийн бонд” гэж Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн бондыг хэлнэ.

1.6.6.“Бусад хөрөнгө” гэж даатгагчийн балансын актив дахь нийт хөрөнгийн дүнгээс энэ журмын 3.1.1-3.1.12-т заасан хөрөнгийг хасч тооцсон хөрөнгийн дүнг хэлнэ.

1.6.7.“Зах зээлийн үнэ” гэж худалдагч, худалдан авагч хоёр зах зээл дээр арилжаа хэлцэл хийж тохирсон үнийг хэлнэ. Энэ нь худалдагч тал зөвшөөрөхөд бэлэн хамгийн бага, худалдан авагч төлөхөд бэлэн хамгийн өндөр үнэ байх юм.

1.6.8.“Анхны өртөг” гэж хөрөнгийг худалдаж авахад төлсөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэд төлсөн дүнг, эсхүл уг хөрөнгийг авахад санал болгосон анхны үнийг хэлнэ.

1.6.9. Энэ журмын 3.1 дэх хэсгийн “Нэгж” гэж тус журмын 3.1.1, 3.1.11-ийн хувьд тус тус арилжааны банк, 3.1.3-ын хувьд Төв банк, 3.1.4-ийн хувьд аймаг, нийслэл, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.13-ын хувьд тус тус хуулийн этгээд, 3.1.8-ын хувьд хувь хүн эсхүл хуулийн этгээдийг хэлнэ.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/*

1.7. Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан “холбогдох этгээд”-д дараах нөхцөлийн аль нэгэнд тохирч буй иргэн, хуулийн этгээдийг хамааруулна.

1.7.1. Даатгалын компанийн толгой болон зэрэгцээ, хараат болон охин компаниуд;

1.7.2. Даатгалын компанийн хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

1.7.3. Барьцаа хөрөнгөгүй, эсхүл барьцаа хөрөнгө нь хангалтгүй буюу барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

1.7.4. Иргэн, эсхүл компанийн удирдлагатай холбоотой хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

1.7.5. Тухайн даатгалын компанийн даатгуулагч;

1.7.6. Даатгалын компанийн холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

### **ХОЁР. Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулахад тавигдах шаардлага**

2.1. Даатгагч хөрөнгө оруулалт хийх болон хөрөнгө байршуулах төлөвлөгөөтэй байх ба уг төлөвлөгөөг энэ журмын хавсралтын дагуу боловсруулна.

2.2. Даатгагч нь хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах төлөвлөгөөгөө жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байх шаардлагатай.

2.3. Даатгагч нь гадаад улс оронд байрлах хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулахыг хүсвэл Хороонд хүсэлтээ бичгээр тавина.

2.4. Даатгагч нь Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр гадаад улс оронд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрнө.

2.5. Даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь энэ журмын 2.1-д заасан хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг явуулна.

2.6. ТУЗ нь даатгалын холбогдох хууль, журмын биелэлт болон хөрөнгө оруулалт хийх болон хөрөнгө байршуулах төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд тогтмол хяналтыг тавина.

2.7.Энэ журмын 3.1-д зааснаас бусад хэлбэрээр даатгагчийн нийт хөрөнгөнөөс хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулахыг хориглоно.

### **ГУРАВ. Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах хязгаар**

3.1.Даатгагч нийт хөрөнгөө дараах хувь хэмжээнд нийцүүлэн байршуулж болно:

Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох дээд хувь
3.1.1.Банкны харилцах, хадгаламж	100%	33.4%
3.1.2.Засгийн газрын бонд	100%	100%
3.1.3.Төв банкны үнэт цаас	60%	60%
3.1.4.Орон нутгийн засаг захиргааны бонд	60%	20%
3.1.5.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	60%	20%
3.1.6.Компанийн бонд	20%	10%
3.1.7.Үл хөдлөх хөрөнгө	20%	20%
3.1.8.Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан богино хугацаат зээл	20%	5%
3.1.9.Буруутай этгээдээр төлүүлсэн нөхөн төлбөр болон даатгагчийн авсан даатгуулагчийн сүйрсэн хөрөнгө (Salvage and subrogation recoveries)	100%	
3.1.10.180 хоногоос доош хугацаатай авлага	20%	
<i>/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>		
3.1.11.Банкны хадгаламжийн сертификат	50	5%
3.1.12.Кассан дахь мөнгө	2%	
3.1.13.Санхүүгийн болон үйл ажиллагааны түрээс	10%	5%
<i>/Энэ заалтыг /Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>		

3.2.Даатгагч хөрөнгө байршуулах хэмжээг тооцохдоо нийт хөрөнгийн дүнг харгалзах хөрөнгө байршуулах хувиар үржүүлж тодорхойлно.

3.3. Нэгжид ногдох дээд хэмжээг тооцохдоо тухайн хөрөнгийн дүнг харгалзах нэгжид ногдох дээд хувиар үржүүлж тодорхойлно. */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/*

### **ДӨРӨВ. Хяналт тавих**

4.1.Даатгагчийн нийт хөрөнгийн байршилд Хороо улирал тутам хяналт тавина.

4.2.Даатгагч хөрөнгө оруулалт хийсэн болон хөрөнгө байршуулсан тайланг Хорооноос тогтоосон маягтын дагуу улирал бүр гаргаж Хороонд ирүүлнэ.

4.3.Хэрэв даатгагч нийт хөрөнгөө энэ журмын 4.1-д заасан хөрөнгө байршуулах дээд хувь болон нэгжид ногдох дээд хувиас илүү хувиар байршуулсан, 1.6.2-1.6.5-д заасан

шаардлагыг хангаагүй хөрөнгөнд байршуулж энэ журмыг зөрчсөн тохиолдолд илүү хувиар байршуулсан болон заасан шаардлагыг хангаагүй хөрөнгийг даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцохдоо 100 хувь зөвшөөрөгдөхгүй хөрөнгөнд оруулж тооцно.

4.4.Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

Санхүүгийн зохицуулах хорооны  
2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн  
170 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**МАЯГТ - Д1-А. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДҮРМИЙН  
САНГИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ**

Даатгагчийн нэр:

20... оны ... сарын ...

Тайлант хугацаа:

(төгрөгөөр)

№	Дүрмийн сангийн хөрөнгийн байршил	Мөрийн дугаар	Зах зээлийн үнэ		Анхны өртөг	
			1-р сарын 1	...-р сарын ...	1-р сарын 1	...-р сарын ...
А	Б	В	1	2	3	4
	<b>ДҮН мөр1=мөр2+мөр3+мөр7+мөр11+мөр(15+... +23)</b>	1				
1	Касс	2				
2	Банкны харилцах	3				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	4				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	5				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	6				
3	Банкны хадгаламж	7				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	8				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	9				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	10				
4	Банкны хадгаламжийн сертификат	11				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	12				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	13				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	14				
5	Засгийн газрын өрийн бичиг	15				
6	Төв банкны үнэт цаас	16				
7	Орон нутгийн засаг захиргааны бонд	17				
8	Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас	18				
9	Компанийн бонд	19				
10	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг	20				
11	Холбогдох этгээдээс бусад этгээдэд Даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл	21				
12	Үл хөдлөх хөрөнгө	22				
13	Бусад	23				
14	үүнээс: .....	24				
15	.....	25				
16	.....	26				

ТАЙЛАН ГАРГАСАН:

*тамга тэмдэг*

*(албан тушаал)*

*(гарын үсэг)*

*(овог нэр)*



**МАЯГТ - Д1-Б. ДААТГАЛЫН КОМПАНИЙН НӨӨЦ  
САНГИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ**

Даатгагчийн нэр:

20... оны ... сарын ...

Тайлант хугацаа:

*(төгрөгөөр)*

№	Нөөц сангийн хөрөнгийн байршил	Мөрийн дугаар	Зах зээлийн үнэ		Анхны өртөг	
			1-р сарын 1	...-р сарын ...	1-р сарын 1	...-р сарын ...
А	Б	В	1	2	3	4
	<b>ДҮН мөр1=мөр2+мөр3+мөр7+мөр11+мөр(15+...+23)</b>	1				
1	Касс	2				
2	Банкны харилцах	3				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	4				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	5				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	6				
3	Банкны хадгаламж	7				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	8				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	9				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	10				
4	Банкны хадгаламжийн сертификат	11				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	12				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	13				
	..... банк (дансны дугаар, дансны төрөл)	14				
5	Засгийн газрын өрийн бичиг	15				
6	Төв банкны үнэт цаас	16				
7	Орон нутгийн засаг захиргааны бонд	17				
8	Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас	18				
9	Компанийн бонд	19				
10	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг	20				
11	Холбогдох этгээдээс бусад этгээдэд Даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл	21				
12	Бусад	22				
13	үүнээс: .....	23				
14	.....	24				
15	.....	25				

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)      (сарын үсэг)      (овог нэр)

тамга тэмдэг

“Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил,  
хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-ын  
хавсралт

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ, ХӨРӨНГӨ БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ**

1. Даатгагч нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), хувь нийлүүлэгчид, үүсгэн байгуулагчдын хурлаар баталсан хөрөнгө оруулалт хийх болон хөрөнгө байршуулах төлөвлөгөөтэй байна.

2. Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана. Үүнд:

2.1. Энэ журмын 3.1-д заасан хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах хувь хэмжээ;

2.2. Энэ журмын 3.1-д заасны дагуу хийсэн даатгагчийн хөрөнгийн хуваарилалт;

2.3. Даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагааны эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;

2.4. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн зохистой харьцаа;

2.5. Даатгуулагчдын өмнө хүлээсэн үүргийн хариуцлага болон байршуулсан хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа;

2.6. Даатгагчийн үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй бусад эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;

2.7. Даатгуулагчдад их хэмжээний нөхөн төлбөрийг нэгэн зэрэг олгож учирсан хохирлыг бүрэн барагдуулах зорилгоор даатгагч нь хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийг шуурхай татан төвлөрүүлэх арга зам.

3. Хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах төлөвлөгөөг энэ журмын 3.1-д заасан хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байх шаардлагатай.

4. Даатгагч хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө байршуулах төлөвлөгөөг компанийн бизнес төлөвлөгөө болон тухайн жилд хийгдэх хөрөнгө оруулалт, хөрөнгийн байршлыг тусган жил бүр боловсруулна.

--ooOoo--